



ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 09 сарын 29 өдөр

Дугаар A/151

Улаанбаатар хот.

Г Шалгуур үзүүлэлт, аргачлал батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Татварын ерөнхий хуулийн 77 дугаар зүйлийн 77.7.1, 77.7.3, 77.7.13, 80 дугаар зүйлийн 80.1, Сангийн сайдын 2020 оны 168 дугаар тушаалаар баталсан “Татварын улсын байцаагчид үр дүнгийн шагнал олгох журам”-ын 2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Татварын улсын байцаагчийн ажлын үр дүнг тооцох, шагнал олгох шалгуур үзүүлэлт, үнэлэх аргачлал”-ыг хавсралтаар баталсугай.

2.Батлагдсан шалгуур үзүүлэлт, аргачлалаар татварын улсын байцаагчийн ажлын үр дүнг тооцож ажиллахыг Татварын ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн болон харьяа нэгж, Нийслэлийн татварын газар, аймаг, дүүргийн татварын хэлтсийн дарга наарт даалгасугай.

3.Татварын улсын байцаагчийн үр дүнгийн шагнал олгоход шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөвт тусгах арга хэмжээ авч ажиллахыг Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс /Л.Бямбадорж/-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Л.Нэргүй/-т тус тус үүрэг болгосугай.

4.Тушаал батлагдсантай холбогдуулан Татварын ерөнхий газрын даргын 2016 оны А/48, 2017 оны А/102, 2019 оны А/71 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.



ДАРГА

Б.ЗАЯАБАЛ

150001980

Татварын ерөнхий газрын даргын
2020 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн
A/151. дүгээр тушаалын хавсралт

ТАТВАРЫН УЛСЫН БАЙЦААГЧИЙН АЖЛЫН ҮР ДҮНГ ТООЦОХ,
ШАГНАЛ ОЛГОХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ҮНЭЛЭХ АРГАЧЛАЛ

Нэг. Ажлын үзүүлэлт

1. Татварын улсын байцаагчийн ажлыг үнэлэхэд дараах үзүүлэлтийг үндэслэнэ.

1.1. Татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, татвар төлөгчийг мэдээллээр ханган зөвлөгөө өгөх, сургалт сурталчилгаа явуулсан байдал;

1.2. Татвар төлөгчийг бүртгэх, татвар ногдуулах, төлөх, тайлагнах, татварын ногдлыг тодорхойлох, татвар хураах, хуульд заасан нийтлэг ажиллагааг хэрэгжүүлсэн байдал;

1.3. Улс, орон нутгийн төсвийн татварын орлогын бүрдүүлсэн байдал;

1.4. Татварын эрсдэлийг тодорхойлох, хяналт шалгалт хийх, гомдол, маргааныг шийдвэрлэх, шүүх, хяналтын байгууллагад татварын албыг төлөөлсөн байдал;

1.5. Бусад байгууллагаас харилцан мэдээлэл солилцох, хамтран ажиллах, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг хөтөлсөн байдал;

1.6. Татварын ерөнхий хууль, Нэмэгдсэн өргтийн албан татварын тухай хуулийн хэрэгжилтийг хангасан байдал;

1.7. Татварын албаны үндсэн чиг үүргийг дэмжих чиглэлээр зохион байгуулсан ажил, Төрийн албаны тухай болон бусад холбогдох хууль тогтоомжийн хэрэгжүүлсэн байдал;

1.8. Энэ аргачлалын 1.1-1.7-т заасан шалгуур үзүүлэлтээр татварын албаны хэмжээнд шинэ санал, санаачлага гарган хэрэгжүүлсэн, сайн туршлага нэвтрүүлсэн байдал;

1.9. Даргын албан үүрэг, шуурхай үүрэг даалгаврыг амжилттай биелүүлсэн, ажлын хэсэгт орж үр дүнтэй ажилласан байдал;

1.10. Бусад;

Хоёр. Ажлын гүйцэтгэлийг тайлагнах, хянах

2.1. Татварын удирдлагын нэгдсэн системээр дамжуулан дараах байдлаар ажлын гүйцэтгэлийг тайлагнаж, үнэлнэ.

2.1.1. Татварын улсын байцаагч ажлын сарын гүйцэтгэлээ тухайн сарын ажлын сүүлийн өдөр татварын удирдлагын нэгдсэн системийн "сарын гүйцэтгэлийн тайлан"-гийн хэсэгт оруулж, шууд удирдах дарга дараа сарын 5-ны өдрийн дотор үнэлнэ.

2.1.2. Ажлын үнэлгээ нь бодит гүйцэтгэлд нийцсэн эсэхийг төрийн захиргааны нэгжийн холбогдох албан тушаалтан дараа сарын 10-ны өдрийн дотор хянан, шууд удирдах даргадаа танилцуулж, төсвийн шууд захирагчийн шийдвэрээр үнэлгээг өөрчилж болно.

2.1.3. Татварын ерөнхий газрын Төрийн захиргааны асуудал хариуцсан нэгж ажлын үнэлгээний ерөнхий хяналтыг хариуцаж, хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн, холбогдох бусад мэдээлэл, баримтад үндэслэн өөрчлөх эрхтэй байна.

Гурав. Үр дүнгийн үзүүлэлт, үнэлэх аргачлал

3.1. Ажлын гүйцэтгэлийг төлөвлөгөөт ажлын биелэлт, шуурхай үүрэг даалгаврын биелэлтийн хувийн дунджаар тогтооно. Төлөвлөгөөт ажлын

биелэлтийн хувийг төлөвлөсөн ажлуудын биелэлтийн хувийн дунджаар, шуурхай үүрэг даалгаврын биелэлтийн хувийг удирдлага, хуралдаан, ажлын хэсгээс өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн хувийн дунджаар тус тус тогтооно.

3.2. Энэ аргачлалын 1.1-1.7-т заасан ажлын гүйцэтгэлийг дараах байдлаар үнэлнэ.

3.2.1.“үр дүнтэй”-зорилт, арга хэмжээ, шалгуур үзүүлэлт нь оновчтой тодорхойлогдсон, хүрэх түвшиндээ бүрэн хүрсэн, үр дүн гарсан бол 90-100 хүртэл хувь;

3.2.2.“тодорхой үр дүнд хүрсэн”-зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, тодорхой үр дүн гарсан, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай бол 80-89 хүртэл хувь;

3.2.3.“үр дүнгүй”-зорилт, арга хэмжээ, шалгуур үзүүлэлтээ оновчтой тодорхойлоогүй, хүрэх түвшиндээ хүрээгүй, үр дүнгүй, үйл ажиллагааг эхлээгүй, эхэлсэн боловч эрчимжүүлэх шаардлагатай бол 0-79 хүртэл хувь;

3.3. Ажлын гүйцэтгэлээр “үр дүнтэй” үнэлэгдсэн бол 16-20, “тодорхой үр дүнд хүрсэн” бол 10-15 хувиар үр дүнгийн шагнал олгож, “үр дүнгүй” гэж үнэлэгдсэн бол үр дүнгийн шагнал олгохгүй.

3.4.“үнэлэх боломжгүй”- төсөв хөрөнгө, гадаад хүчин зүйл, удирдах байгууллага, албан тушаалтны шийдвэрээс шалтгаалсан зэргийг баримтаар нотолсон бол үнэлэхгүй.

3.5. Татварын улсын байцаагчийн ажлын сарын гүйцэтгэлийг дараах аргачлалаар нарийвчлан тогтооно. Тухайлбал ажлын гүйцэтгэл 87 хувь бол / $13.8=10+3.1$, $3.8=(87-80)/(15-10)*(89-80)$ / 13.8 хувиар тооцож үр дүнгийн шагнал олгоно.

3.6. Татварын ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн болон харьяа нэгж, Нийслэлийн татварын газар, аймаг, дүүргийн татварын хэлтэс, тасаг /цаашид “нэгж” гэх/-ийн дарга үнэлнэ.

3.7. Нэгжийн даргын үр дүнгийн шагнал олгох хувийг түүний шууд удирдлагад ажиллах татварын улсын байцаагчийн ажлын үр дүнгийн шагналын хувийн дунджаар тогтооно.

Дөрөв. Үр дүнгийн шагналыг нэмэгдүүлэх, олгох

4.1. Дараах үндэслэлээр үр дүнгийн шагналыг 30 хүртэл хувиар нэмэгдүүлнэ.

4.1.1. Энэ аргачлалын 1.1-1.7-т заасан шалгуур үзүүлэлтийн хүрээнд бүрэн хангалттай үнэлгээ, ажлын гүйцэтгэлийн тайлан, Татварын ерөнхий газрын зохион байгуулалтын болон харьяа нэгж, Нийслэлийн татварын газар, аймаг, дүүргийн татварын хэлтсийн даргын саналыг үндэслэн;

4.1.2. Энэ аргачлалын 1.8-д заасны дагуу шинэ санал, санаачлага хэрэгжүүлсэн, сайн туршлага нэвтрүүлсэн татварын улсын байцаагчийн ажлын тайлан, Татварын ерөнхий газрын зохион байгуулалтын болон харьяа нэгж, Нийслэлийн татварын газар, аймаг, дүүргийн татварын хэлтсийн даргын тодорхойлолтыг үндэслэн;

4.1.3. Энэ аргачлалын 1.9-д заасны дагуу Татварын ерөнхий газар, төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр ажлын хэсэгт орж ажиллан үр дүн гаргасан, Татварын ерөнхий газрын даргын албан үүрэг, шуурхай үүрэг даалгаврыг хугацаанд нь амжилттай хэрэгжүүлсэн тайлан, зохион байгуулалтын нэгжийн даргын саналыг үндэслэн;

4.2. Энэ аргачлалын 4.1-д заасан үр дүнгийн шагналыг нэмэгдүүлэх санал, холбогдох материалыг Татварын ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн болон харьяа нэгж, Нийслэлийн татварын газар, аймаг, дүүргийн татварын хэлтсийн дарга нь дараа сарын 10-ны өдрийн дотор татварын удирдлагын нэгдсэн системийн “Үр дүнгийн шагнал” хэсэгт оруулна.

4.3. Татварын ерөнхий газрын Төрийн захиргааны асуудал хариуцсан нэгж дээрх саналыг хянан, ажлын 5 хоногийн дотор тус газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлж, үр дүнгийн шагналыг нэмэгдүүлэх хувийг дээрх програмын хэсэгт оруулна.

4.4. Үр дүнгийн шагналыг олгох асуудлыг Татварын ерөнхий газар, харьяа нэгж, Нийслэлийн татварын газар, аймаг, дүүргийн татварын хэлтсийн даргын тушаалаар шийдвэрлэж, дараа сарын сүүлийн цалинтай хамт олгоно.

4.5. Татварын улсын байцаагчийн ажлын 12 дугаар сарын гүйцэтгэлийг тухайн сард багтаан урьдчилан тайлагнах, үнэлэх, үр дүнгийн шагнал олгохыг татварын албадын төрийн захиргааны нэгж хариуцан зохион байгуулна.

Тав. Бусад

5.1. Татварын улсын байцаагчийн ажлын гүйцэтгэлийг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр тайлагнаагүй, үнэлээгүй тохиолдолд үр дүнгийн шагнал олгохгүй.

-оОо-